



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 02 сарын 09 өдөр

Дугаар А/ 111.

Номгон

Хөрөнгийн татвар төлөгчдийн бүртгэл мэдээллийн зөрүүг арилгах, холбогдох хуулиудын хэрэгжилтийг хангах тухай


Хөрөнгийн татвар төлөгчдийн бүртгэл мэдээллийн зөрүүг арилгах, үл хөдлөх эд хөрөнгийн үнэлгээг бодитоор үнэлэх, холбогдох хууль тогтоомжийг иргэд олон нийтэд сурталчлан таниулах, хэрэгжилтийг хангах зорилгоор Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйл 29.1.1 е, аймгийн 2021 оны хөгжлийн төлөвлөгөөний 47 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хөрөнгийн татвар төлөгч хувь хүн, аж ахуйн нэгжүүдийн хөрөнгийн бүртгэл мэдээллийн зөрүүг арилгаж, үл хөдлөх эд хөрөнгийн үнэлгээг бодитоор үнэлэх ажлыг зохион байгуулсугай.

2. Хөрөнгийн татвар төлөгч хувь хүн, аж ахуйн нэгжүүдийн хөрөнгийн бүртгэл мэдээллийн зөрүүг арилгаж, үл хөдлөх эд хөрөнгийн үнэлгээг бодитоор үнэлэхэд арга хэмжээ авч ажиллахыг Татварын хэлтэс /С.Рэнцэндагва/-т, мэдээллийн зөрүүг арилгахад дэмжлэг үзүүлж хамтран ажиллахыг аймгийн Цагдаагийн газар /Б.Оюутболд/, Улсын бүртгэлийн хэлтэс /Ц.Мөнхжаргал/, Автотээврийн төв /С.Амармөнх/ нарт тус тус үүрэг болгосугай.

3. Дээрх үйл ажиллагаанд шаардагдах 8,000,000 /найман сая/ төгрөгийг аймгийн 2021 оны хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /С.Байгалмаа/-д зөвшөөрсүгэй.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Байгаль орчин, уул уурхай, нийгмийн салбар хариуцсан орлогч /Г.Энхбаяр/-д үүрэг болгосугай.



ДАРГА

Д.МӨНХСАЙХАН